

АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР ЗҮЛЭГТ 12 ДУГААР БАГИЙН НИЙГМИЙН АЖИЛТАН
ОДСҮРЭНГИЙН МӨНХЦЭЦЭГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д /д	Хүрэх түвшин	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)			
	1	2	3	4	5	6	7	
Зорилт 1. "Хууль болон бодлого шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллах"								
1.	Арга хэмжээ 1.1 "Халамжаас хөдөлмөрт бэлтгэх" хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах	1.1.1. Орлого нэмэгдсэн өрхийн тоогоор	7	8	Хүнсний эрхийн бичигт хамрагддаг 42 өрхөөс өөрийн хүсэлтээр гарсан 3, орлого нэмэгдсэн өрх 5 нийт 8 өрх хүнс тэжээлийн хөтөлбөрөөс хасагдсан. Хүнс тэжээлийн хөтөлбөрт хамрагддаг 34 өрх болсон байна.	2024.01.02 2024.11.25	100	
		1.1.2.Хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамрагдсан иргэний тоо	48	35	1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2024 онд хэрэгжүүлэх "Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаа"-ны хүрээнд эмэгтэйчүүдэд зориулсан богино хугацааны ур чадварын худалдааны зөвлөх сургалтад хүнс тэжээлийн хөтөлбөрт хамрагддаг 8 өрхийн 8 иргэн хамрагдсан. 2.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн зөвлөгөө мэдээлэл өгөх сургалтад зорилтот бүлгийн 15 иргэн хамрагдсан. 3.Цахим шилжилтийг эрчимжүүлэх" зорилтот жилийн сургалтад хүнс тэжээлийн хөтөлбөрт хамрагддаг 11	2024.01.02 2024.11.25	100	

					өрхийн 14 иргэн хамрагдсан. 4. Малчдын туршлага солилцох уулзалт зөвлөгөөнд малжуулах төсөлд хамрагдсан 1 өрх хамрагдав. Нийт 38 иргэн хамруулав.		
2.	Арга хэмжээ 1.2. Батийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн нарийвчлан судалгааг гаргаж, хөдөлмөр эрхлээгүй иргэдийг сургалтад хамруулах, ажилд зуучлах	1.2.1. Мэргэжлийн чиг баримжаа олгох болон амьдрах ухааны сургалтад хамрагдсан иргэдийн хувиар	29	50	Хөдөлмөр эрхэлдэггүй хөдөлмөрийн насны 89 иргэний дэлгэрэнгүй судалгааг гаргасан. Мэргэжил олгох сургалтад худалдааны зөвлөх 8, оёдол 5, тогооч 6, үсчин 6, нярав 4 нийт 29 иргэн хамрагдсан. Амьдрах ухааны сургалтад 15 иргэн хамрагдсан. Хөдөлмөр эрхэлдэггүй 89 иргэдээс 50% хамрагдсан.	2024.01.02 2024.11.25	50
		1.2.2. Байнгын ажлын байранд зуучилсан иргэдийн тоогоор	3	4	Байнгын ажилд "Их богд" хоолны газар үйлчлэгч 1, бэлтгэгч 1, Арвайхээр сумын ЗДТГазрын өвс, ногооны зооринд сахиул 1, "Төгөл" барилгын дэлгүүрт туслах 1 нийт 4 иргэнийг холбон зуучилсан.	2024.01.02 2024.11.25	100
		1.2.3. Түр ажлын байр болон улиралын чанартай ажлын байранд зуучилсан иргэний тоогоор	36	20	Нийтийг хамарсан ажилд: Нийтийн эзэмшлийн газар хог цэвэрлэх 7, сэг зэм цэвэрлэх 1, мод тарих 3, шарилж зулгаах 4, Улирлын чанартай ажилд: Ихэр-Од буудалд 1, Их богд хоолны газар бэлтгэгч 1, тоосгоны үйлдвэрт өрөгч 1, арьс ширний үйлдвэрт зумлагч 1, мах савлагч 1, Нийт 20 иргэнийг холбон зуучилсан.	2024.01.02 2024.11.25	100
3.	Арга хэмжээ 1.3. Нэг өрх-Нэг ажлын байр хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	1.3.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувиар	90	100	"Нэг өрх-Нэг ажлын байр" хөтөлбөрт 7 өрх хамрагдаж судалгаанд баяжилт хийж, төсөлд хамрагдсан 6 өрхийн, 6 иргэнийг хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамруулж 4 иргэнийг ажилд холбон зуучилсан. Швейцарийн холбооны улсын "Ла Мэнса Э Ил Грэхжэ" төрийн бус байгууллагын санхүүжилтээр "Сайхан монголын өнгө" төрийн бус байгууллага Арвайхээр сумын ЗДТГ-тай хамтран "Ногоо тарья" төслийг хэрэгжүүлсэн бөгөөд "Нэг өрх-Нэг ажлын байр" хөтөлбөрт хамрагдаж 1 иргэн хамруулав. Хөгжлийн шийдэл ТББ, Бэст хөтөлбөрийн сургалтад 1 иргэн	2024.01.02 2024.11.25	100

				хамрагдсан.Хөтөлбөрийн хэрэгжилт хувьтай байна.	90		
4.	Арга хэмжээ 1.4. Хувираа эрхлэгчдийн даатгалын мэдээллийн сантай болох	1.4.1. Судалгаа мэдээллийн санд баяжилт хийсэн тоогоор	21	34	Хувираа хөдөлмөр эрхэлдэг иргэдийн судалгаанд баяжилт хийж нийт 123 иргэн байгаагаас үүнээс 34 иргэн сайн дурын нийгмийн даатгал төлдөг. Өмнөх оны энэ үетэй харьцуулахад 13 иргэнээр өссөн дүнтэй байна.	2024.01.02 2024.11.25	100
5.	Арга хэмжээ 1.5. Ахмад настны нийгмийн оролцоог хангах	1.5.1. Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор	4	10	Ахмад настан 134 өрхийн, 162 ахмад байгаагаас байгууллагын харьяалалгүй 123 ахмад байна. 1.9,12 дугаар баг хамтран “Баясах өдөр” арга хэмжээ 2.“Уянсэтгэл” ӨЭМТөв нь Аймгийн Эрүүл мэндийн газар, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Эм гоо ХХК хамтран “Ахмад настан”-д тусламж үйлчилгээ байнгын асаргаанд байдаг ахмад болон асран хамгаалагч нарын эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах нээлттэй хаалганы өдөрлөг 3.Уянсэтгэл ӨЭМТөвийн хүсэлтээр Рафаэл Интернэйшнл ТББайгууллага зорилтот бүлэг болон ахмад настанд урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ, оношилгоо 4.“Арвайхээр-2024” хотын аварга шалгаруулах нийтийн бүжгийн тэмцээн 5.“Бүх нийтийн соёл, урлагийн боловсролын өдрүүд” арга хэмжээнд зохион багуулагдаж амьсгалын дасгал, шугаман бүжиг 6. “Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорил 7.“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд ахмад настны бие бялдрыг чийрэгжүүлэх, тэднийг хөдөлгөөний хомсдол болон халдвар бус	2024.01.02 2024.11.25	100

				өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, дасгал хөдөлгөөнөөр хичээллэгсдийн тоог нэмэгдүүлэх зорилготой "Бие чийрэгжүүлэх найман дасгал" хийн дасгал 8.Аймгийн аварга шалгаруулах бүсийн шугаман бүжгийн тэмцээн 9.Эрүүл чанартай урт наслахын төлөө нэгдсэн өдөрлөг 10.Өдөр өнжүүлэх, сувилал		
1.5.2. Эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулсан хувь	80	80		1."Уянсэтгэл" ӨЭМТөв нь Аймгийн Эрүүл мэндийн газар, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Эм гоо ХХК хамтран "Ахмад настан"-д тусламж үйлчилгээ үзүүлэх сайжруулах нь нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулагдсан. Артерийн даралт хэмжиж, БЖИ тодорхойлж, ахмад настны эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хэвтрийн өвчтөний асаргаа сувилгаа, сэтгэл зүйн сургалт, зөвлөгөө, нийгмийн халамжийн төсөл хөтөлбөрүүд эрүүл хооллолт, дасгал хөдөлгөөний талаар сургалт зохион байгуулж, эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн нэр төрөл, үнийн мэдээлэл болон эмийн зохистой хэрэглээний талаар мэдээлэл авсан ахмад 27 2.Рафаэл Интернэйшнл ТББайгууллага ахмад настанд урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ, оношилгоо зохион байгуулагдаж ахмад 32 3.Өгөөмөр сувилал 14, Ариунсанаа эмнэлэг 10, Ахмадын өргөө өдөр өнжүүлэх 7, Улаан загалмайн өдөр өнжүүлэх 5 4.Эрүүл чанартай урт наслахын төлөө нэгдсэн өдөрлөг ахмадын өргөөнд зохион байгуулагдаж 27 ахмад оролцож давхардсан тоогоор нийт 122 ахмадыг хамруулан ажиллав. Нийт 162 ахмадын 75	2024.01.02 2024.11.25	100

					хувь нь хамрагдсан байна.		
					1.Эрүүл мэнд, бие бялдрын хөгжлийг нэмэгдүүлэх, дээшлүүлэх зорилтын хүрээнд нийтийн бүжгийн спортыг иргэдэд сурталчлах түгээн дэлгэрүүлэх, иргэд нийтийн бүжгээр хичээллэх сонирхлыг төрүүлэх, нөхцөл боломжийг бий болгох, ур чадварыг нээх "Арвайхээр-2024" хотын аварга шалгаруулах нийтийн бүжгийн тэмцээнд 3 ахмад, 56-с дээш насны төрөлд 2 иргэн оролцож 2 дугаар байр эзэлсэн.		
					2."Бүх нийтийн соёл, урлагийн боловсролын өдрүүд" арга хэмжээнд зохион багуулагдаж амьсгалын дасгал, шугаман бүжигт 24, нийтийн цэнгээнт бүжигт 12		
					3."Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилд 26		
1.5.3. урлаг, бусад хэмжээнд хамруулсан хувь	Соёл спорт, арга	80	80		4.МУ-ын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй "Эрүүл Монгол хүн" үндэсний хөдөлгөөний хүрээнд ахмад настны бие бялдрыг чийрэгжүүлэх, тэднийг хөдөлгөөний хомсдол болон халдвар бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, дасгал хөдөлгөөнөөр хичээллэгсдийн тоог нэмэгдүүлэх зорилготой зохион байгуулагдсан "ХИЙН ДАСГАЛ"-ын сумын аварга шалгаруулах тэмцээнд 9 ахмад оролцож "ТЭРГҮҮН" байр мөн Өвөрхангай аймгийн аварга шалгаруулах тэмцээнд "ХОЁРДУГААР" байранд тус тус шалгарч амжилттай оролцсон. 5.Шугаман бүжигт 3 ахмад оролцож гутгаар байранд орсон.	2024.01.02 2024.11.25	100
					6."Баясах өдөр" арга хэмжээ зохион байгуулж 130 ахмад оролцсоноос 72 ахмад 12 дугаар багаас оролцсон.		
					Давхардсан тоогоор нийт 149 ахмад		

					оролцсон. Нийт ахмадын 90 хувь нь хамрагдсан.				
					Нийгмийн халамжийн үйлчилгээнээс харъяалалгүй ахмадуудад олгогддог мөнгөн тэтгэмжид 01 сард 120, 09 сард 123 ахмад хамрагдсан. Тусгай хэрэгсэлд суултуур 2, шүд 6, таяг 8, тэргэнцэр 1, алхагч 1, сонсголын аппарат 2, бүс 2, хүзүүвч 3, бөөрний даруулга 5, байнгын асаргаанд 13 ахмад байна. Ганц биеэр өрх үүсгэн амьдардаг амжиргааны баталгаажих түвшинээс доогуур орлоготой 4 ахмадыг Арвайхээр сумын Засаг даргын нөөцөөс түлшний дэмжлэгт хамруулсан. ХХҮГазрын түлшний үнийн хөнгөлөлтөд хүндэт донор 2, ардын их хурлын депутат 1, төрүүлж өсгөсөн үр хүүхэдгүй ахмад 2. Амжиргаа дэмжих зөвлөлийн хурлаар 5 ахмадын байнгын асаргаатай сунгалт хийгдсэн. Давхардсан тоогоор нийт 175 ахмадыг нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулсан.	80	80	2024.01.02 2024.11.25	100
		1.5.4. Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулсан ахмадын хувь							
6.	Арга хэмжээ 1.6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог хангах	1.6.1. Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор	7	9	1."Эх дэлхий- Элгэн нутаг" зорилтот байгаль хамгааллын өдөрлөг 2.ОУ-ын эмэгтэйчүүдийн эрхийг хамргаалах өдрийг тохиолдуулан зорилтот эмэгтэйчүүдэд чиглэсэн "Ерөн есөн сарнай" нөлөөллийн арга хэмжээ 3."Одоо л больё" арга хэмжээ 4."Бүтээлч гар НҮТББ"-с хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сонгуулийн боловсрол олгох сургалт 2 удаа 5. Эрүүл чийрэг-Өвөрхангайчууд спортын арга хэмжээ 6."Цахим шилжилтийг эрчимжүүлэх" зорилтот жил сургалт 3 удаа 7.Бүх нийтийн гүйлт-2024 8."Бүтээлч гар НҮТББ"-с хөгжлийн	2024.01.02 2024.11.25	100		

					бэрхшээлтэй сонгогч нарт санал авах байр хүртээмжтэй байдлаар зохион байгуулсан эсэхт хүртээмжийн үнэлгээ хийх сургалт 9.Бие бялдрын түвшин тогтоох сорил				
					1."Эх дэлхий- Элгэн нутаг" зорилтот байгаль хамгааллын өдөрлөгт 6 2.ОУ-ын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан зорилтот эмэгтэйчүүдэд чиглэсэн "Ерөн есөн сарнай" нөлөөллийн арга хэмжээ 7 3."Одоо л больё" арга хэмжээнд 2 4."Бүтээлч гар НҮТББ"-с хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сонгуулийн боловсрол олгох сургалт 2 удаа зохион байгуулагдаж 12 5. Эрүүл чийрэг-Өвөрхангайчууд спортын арга хэмжээнд 5 6."Цахим шилжилтийг эрчимжүүлэх" зорилтот жилд 14 7.Бүх нийтийн гүйлт-2024 1 8."Бүтээлч гар НҮТББ"-с хөгжлийн бэрхшээлтэй сонгогч нарт санал авах байр хүртээмжтэй байдлаар зохион байгуулсан эсэхт хүртээмжийн үнэлгээ хийх сургалтад 5 9.Бие бялдрын түвшин тогтоох сорилд 2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд зохион байгуулагдсан соёл урлаг, спорт бусад 9 арга хэмжээ зохион байгуулагдаж давхардсан тоогоор нийт 54 хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамрагдсан.	39	50	2024.01.02 2024.11.25	100
	1.6.2. Соёл урлаг, спорт, бусад арга хэмжээнд хамруулсан хувь								
	1.6.3. Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулсан	100	100		Хөгжлийн бэрхшээлтэй 60 иргэн байгаагаас төрөлхийн 28, олдмол 32, байнгын асаргаатай насанд хүрсэн иргэн 5, хүүхэд 5 байна. Амжиргаа дэмжих хурал 11 удаа хуралдаж үүнээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байнгын асаргааны сунгалт 6, асран хамгаалагчаа солиулах 2, шинээр асаргаанд орсон 3, түлшний хөнгөлөлт 18 нийт 32 материал	2024.01.02 2024.11.25	100		

	иргэдийн хувь			дэмжигдсэн. Дэлхийн зөн МОУБ-аас хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй малчин 2 өрхөд хүнсний багцын тусламж үзүүлсэн. Харилцаа холбооны хөнгөлөлт 2, унааны зардлын хөнгөлөлт 2, үерийн улмаас усанд автаж гэрийн хаалга нь эвдэрсэн 1 өрхөд сумын ЗДТГазраас буцалтгүй дэмжлэг үзүүлж шинэ хаалга, хөгжлийн бэрхшээлтэй иргэний дэмжих зээлд 1 иргэнийг холбон зуучилсан. Нийт 40 иргэнийг нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулан ажиллав.		
	1.6.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сургууль, цэцэрлэгт хамрагдалтын хувь	80	100	Хөгжлийн бэрхшээлтэй 5 хүүхэд байгаагаас 12 дугаар цэцэрлэгт 1, тусгай цэцэрлэг, сургуульд 2, ЕБ-ын 4-р сургуульд 2 суралцаж байна.	2024.01.02 2024.11.25	100
7.	Арга хэмжээ 1.7. Багийн хүүхэд хамгааллын хамтарсан багийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангаж, үр дүнд хүрэх			Хамтарсан баг 2024 оны төлөвлөгөө гарган багийн Засаг даргаар батлуулан 4 удаа хуралдаж эхний хуралдаанаар төлөвлөгөөг танилцуулж нууцийн гэрээ байгуулсан. Гэр бүлийн хүчирхийлээс урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувьтай байна.	2024.01.02 2024.11.25	100
	1.7.2. Үр дүнтэй хаасан кейсийн хувиар	60	100	Энэ оны эцсийн байдлаар хүүхэд хамгааллын хамтарсан баг 3 кейс дээр ажилласан. Хүүхдээ зодож шийтгэсэн 1, гэрээсээ дайжсан 1, хүүхдийн мөнгөн тэтгэмж 1 нийт 3 кейс дээр ажиллаж үр дүнтэй хаасан.	2024.01.02 2024.11.25	100
	1.7.3. Хүүхдийн эрсдлийн мэдээллийн санд баяжилт хийсэн тоогоор	2	1	НАМС программын шинэчлэлт хийгдэж дуусаагүй байгаа тул баяжилт хийгдээгүй болно. Хүүхдийн тусламжийн 108 утасны программд өмнөх оны 1 кейсийн материалыг оруулж хаасан.	2024.01.02 2024.11.25	100
	Арга хэмжээ 1.8.			1.Дэлхийн зөн олон улсын байгууллага		

8.	Гэр бүлийн хөгжил, төлөвшилд чиглэсэн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах	1.8.1. Залуу гэр бүлийн хөгжил, төлөвшилд чиглэсэн сургалт, арга хэмжээний тоогоор	3	2	"Дулаан өвөлжье" малчидтай уулзалт зохион байгуулж бага насны олон хүүхэдтэй 2 залуу малчин өрхөд сургалт мэдээлэл өгөн хүнсний багцын дэмжлэгт хамруулав. 2."Жаргалтай гэр бүл-Жаргалтай амьдрал" гэр бүлийн арга хэмжээнд 2 залуу гэр бүлийг хамруулав. 3.ӨТЭх 1,3,7,10 насны 4 хүүхэдтэй 5 ханатай гэр нь хүчтэй шуурганд нурж, бүрээс нь урагдан эсгий туураг нь норж илжирсэн эрсдэлт нөхцөлд амьдарч байсныг холбон зуучилж Арвайхээр ЗДТГазрын нөөц хөрөнгөнөөс 1 сая төгрөгийн буцалтгүй дэмжлэгт хамруулан групп, байнгын асаргаанд хамруулсан. 4. Энэ оны 8 сард хүчтэй усархаг, аадар борооны улмаас гэр нь нурж уерт аетсан 1 залуу гэр бүлийг холбон зуучилж гэрийн модны буцалтгүй тусламжид хамруулав. 5.Залуу малчин өрхийг дэмжих зорилгоор малжуулах төсөлд 1 өрхийг хамруулсан. 6.Зорилтот залуу гэр бүлийг дэмжих зорилгоор Архангай аймгийн хүүхдийн "Тамир" зусланд 2 хүүхэд хамруулсан. 7.15-34 насны залуучуудын фокус бүлгийн ярилцлагад 1 иргэн оролцов.	2024.01.02 2024.11.15	100
		1.8.2. Тэмдэглэлт баярыг угтан зохион байгуулсан нөлөөллийн ажлын тоогоор	-	4	1.Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр 2.Эх үрсийн баярын өдрийг тохиолдуулан Зүлэгт 12 дугаар багийн Facebook цахим сүлжээгээр Хүүхдийн эрхийн тухай хууль, Эцэг, эх асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүрэг 2 видеоконтент хийн түгээсэн. 3.Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг өдөрт 13 баг хамтран иргэдэд хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэх брошур, мэдээлэл хүргэж ажилласан. 4.Монгол улсад орчин цагийн музей	2024.01.02 2024.11.25	100

					байгуулагдсаны түүхт 100 жилийн ойн хүрээнд, Эх орончдын өдрийг тохиолдуулан Өвөрхангай аймгийн музейтэй хамтран түүх соёлын дурсгалт зүйл, өв уламжлалаа хамгаалах, урлагын бүтээлээр дамжуулан зорилтот бүлгийн 5 хүүхдийг үнэ төлбөргүй үзүүлэв.	1	
9.	Арга хэмжээ 1.9. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах	1.9.1. Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар	90	100	1.Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр "Явуулын үйлчилгээ"-г Арвайхээр сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль, "Энх тал" супермаркет, Авто тээврийн төвийн гадна талбайд зохион байгуулж 35 иргэнд хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл, гарын авлага, зөвлөмж өгч ажилласан. Аймгийн Цагдаагийн газартай хамтран архины хамааралтай, гэмт хэрэгт холбогдох эрсдэлтэй 7 өрхөд гэр айлчлал хийн, багийн гудамж, талбай, хүүхдийн тоглоомын талбайд 19:00-22:00 цагийн хооронд оройн эргүүл хийн, хяналт тавьж ажилласан. 2.Өвөрхангай аймгийн БШУГазрын сэтгэл зүйчидтэй хамтран Арвайхээр сумын иргэдэд сэтгэл зүйн сургалт, зөвлөгөө өгөх "Сэтгэл зүйн эрүүл мэндээ хамгаалъя" өдөрлөгт багийн эрсдэл бүлгийн 5 иргэн хамрагдсан. 3.БООТөвийн Сэтгэц наркологиын тасагт архины хамааралтай 1 иргэнийг 2 удаа хэвтүүлсэн. 4.Монгол улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 43 дугаар зарлигийн хэрэгжилтийг хангах, иргэн, аж ахуй нэгж байгууллагад архи согтууруулах ундааны зохисгүй хэрэглээ түүний хор хөнөөлийн талаар ойлгуулах, цаашлаад үүсэж болох өвчлөлөөс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа нөлөөллийн ажлыг иргэд, олон нийтэд	2024.01.02 2024.11.25	100

				хүргэн ажиллах 15 хэсгийн ахлагч, 5 архины хамааралтай нийт 20 иргэнийг "Одоо л больё" нэгдсэн арга хэмжээнд хамруулсан. 5.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 12 төрлийн брошур, тараах материал 2 удаа, электрон тамхины хор уршигийг сурталчилсан постер, 102, 107, 108 дуудлага утасны постер хэвлэн гаргаж 4 төрлийн нийт 52 ширхэг постерыг 2 усан, 11 дэлгүүрийн мэдээллийн самбарт 1 удаа байршуулсан. 6.Хэсгийн байцаагч, багийн цагдаатай хамт 11 ААН-эгж, 8 нэрийн 10 хүнсний дэлгүүрүүдээр явж камерны хэвийн ажиллагаанд хяналт тавьж бүртгэлжүүлсэн. 7."Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх" арга хэмжээний хүрээнд гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг ахуйн хүрээнд архидан согтуурдаг 8 өрхөөр гэр айлчлал хийв. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөрийн хэрэгжилт 90 хувьтай байна.			
1.9.2. Гэр бүлийн хүчирхийллийн гомдол мэдээллийн шийдвэрлэлтийн хувиар	100	100	100	Он гараад гэр бүлийн хүчирхийллийн гомдол, мэдээлэл 3 ирсэн. Мэдээллийн дагуу 2 дуудлага дээр нь кейс нээж, 1 дуудлага дээр нь хууль эрх зүйн зөвлөмж өгч шийдвэрлэсэн. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад өсөлт, бууралтын өөрчлөлтгүй хэвийн байна.	2024.01.02 2024.11.25	100	
				1.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс зохион байгуулсан төрийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, тэдэнтэй хамтран ажиллах, тэднээр дамжуулан зорилтот бүлгийн иргэдэд архи согтууруулах ундааны хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх "Хамтдаа сэргийлж-Манлайлая"			

1.9.3. Хохирогчид үзүүлэх үйлчилгээ, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт, арга хэмжээнд хамруулсан иргэний тоогоор	70	80	нэгдсэн арга хэмжээнд багийн 3 хэсгийн ахлагч хамрагдсан. 2.Прокурорын газар, ГХУССЗөвлөлийн хамтран зохион байгуулсан сургалтад 4 хэсгийн ахлагч хамрагдсан. 3.Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Явуулын үйлчилгээ”-г Арвайхээр сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль, “Энх тал” супермаркет, Авто тээврийн төвийн гадна талбайд зохион байгуулж 35 иргэнд хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл өгсөн. 4.Цагдаагийн газартай хамтран архины хамааралтай, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх эрсдэлтэй 7 өрхийн 13 иргэнийд гэр айлчлал хийн хяналт тазин ажиллав. 5.”Сэтгэл зүйн эрүүл мэндээ хамгаалъя”өдөрлөг зохион байгуулагдаж архины хамааралтай болон зорилтот бүлгийн 5 иргэн хамрагдсан. 6.Цагдаагийн газар, Ус цаг уур орчны шинжилгээний газартай хамтран Цагаан бургас, Онги гол, Олон довын гарам, Дайргын гол орчимгоор 6,7 сард 2 удаа эргүүлд гарч гол усны эргээр амарч, зугаалж байгаа иргэд болон асран хамгаалагчдад уер, усны аюул болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, бага насны хүүхдэд тавих хараа хяналтаа сайжруулах, архидаан согтуурсан үедээ гол ус руу орохгүй байх, “Гэртээ эрт харъя” аяны хүрээнд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлж голын ойр орчимын малчин өрхүүд болон аялагч, амрагч нийт 63 иргэнд зөвлөмж сэрэмжлүүлэг, мэдээлэл хүргэн ажилласан.Нийт 123 иргэнд мэдээлэл өгч ажиллав.	2024.01.02 2024.11.25	100
---	-----------	-----------	---	----------------------------------	------------

Зорилт 2. “Байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх”

1. Арга хэмжээ 2.1. Иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалтыг боломжит хэлбэрээр байгуулах	2.1.1. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан иргэдийн тоогоор	1235	1346	"Уянсэтгэл" ӨЗМТөвийн нөхөн үржихүйн 15-49 насны эмэгтэйчүүдэд урьдчилан сэргийлэх эхо үзлэгт 245, умайн хүзүүний эсийн шинжилгээнд 167, хөхний хорт хавдрын эрт илрүүлэгт 138, чихрийн шижин өвчний эрт илрүүлэгт 178, артерийн гипертензийн эрт илрүүлэгт 135, элэгний хорт хавдрын илрүүлэг болон В,С вирус 258 иргэн хамрагдсан. 0-5 насны хүүхдийн өндөр, жингийн хэмжилтэд 225 хүүхэд хамрагдсан. Нийт 1346 иргэд хамрагдсан.	2024.01.02 2024.11.25	100
2.1.2. Эрүүл мэндийн олон талт арга хэмжээ зохион байгуулсан арга хэмжээний тоогоор		-	4	1. Уянсэтгэл ӨЗМТөвтэй хамтран "Эрүүл хүүхэд-Бидний ирээдүй" 2-5 насны хүүхдийн эрт илрүүлгийн үзлэг зохион байгуулсан. 2-5 насны хүүхдүүдийн дунд эрт илрүүлгийн үзлэг шинжилгээнд хамруулан, суурь өвчлөлийг илрүүлэн эмчлэн эрүүлжүүлэх ажил зохион байгуулж 67 хүүхэд, 23 насанд хүрсэн иргэн, нийт 90 иргэн хамрагдав. Хүүхдүүдэд цайр, витамин Д, витамин С, өсөлтийн хоцрогдолтой хүүхдэд бичил тэжээл олгосон. Хүүхдүүдийн өндөр, жин, биеийн жингийн индекс, толгойн тойрог, бугалганы тойрог хэмжсэн, цусны ерөнхий шинжилгээ, шүдний ерөнхий үзлэг, эцэг, эх асран хамгаалагчдыг эхо болон умайн хүзүүний эсийн шинжилгээнд хамруулж гарын авлага, брошуур тараасан. 2. "Уянсэтгэл" ӨЗМТөв нь Аймгийн Эрүүл мэндийн газар, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Эм гоо ХХК хамтран "Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй, хөнгөвчлэх тусламж үйлчилгээ шаардлагатай зорилтот бүлгийн иргэд болон асран хамгаалагч нарын эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах нь" нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулагдсан. Артерийн даралт хэмжиж, БЖИ тодорхойлж, ахмад настны эрүүл	2024.01.02 2024.11.25	100

				мэндийн тусламж үйлчилгээ, хэвтрийн өвчтөний асаргаа сувилгаа, сэтгэл зүйн сургалт, зөвлөгөө, нийгмийн халамжийн төсөл хөтөлбөрүүд эрүүл хооллолт, дасгал хөдөлгөөний талаар сургалт зохион байгуулж, эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн нэр төрөл, үнийн мэдээлэл болон эмийн зохистой хэрэглээний талаар 27 ахмад хамруулав.			
				3. Уянсэтгэл ӨЭМТөвийн хүсэлтээр Рафаэл Интернэйшнл ТББайгууллага зорилтот бүлэг болон ахмад настанд урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ, оношилгоо зохион байгуулсан. Үзлэгт нийт 64 иргэн хамрагдсан.			
				4.Эрүүл чанартай урт наслахын төлөө нэгдсэн өдөрлөг ахмадын өргөөнд зохион байгуулагдаж 27 ахмад оролцсон.			
				1."Сэтгэл зүйн эрүүл мэндээ хамгаалъя"өдөрлөг зохион байгуулагдаж архины хамааралтай болон зорилтот бүлгийн 5 иргэн хамрагдсан.			
				2. Багт үйл ажиллагаа явуулдаг 8 нэрийн хүнсний дэлгүүрт согтууруулах ундаа, электрон тамхины хор уршиг сургалт			
				3. Монгол улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 43 дугаар зарлигийн хэрэгжилтийг хангах, иргэн, аж ахуй нэгж байгууллагад архи согтууруулах ундааны зохисгүй хэрэглээ түүний хор хөнөөлийн талаар ойлгуулах, цаашлаад үүсэж болох өвчлөлөөс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа нөлөөллийн ажлыг иргэд, олон нийтэд хүргэн ажиллах 15 хэсгийн ахлагч, архины хамааралтай 5 иргэнийг "Одоо л больё" нэгдсэн арга хэмжээнд хамруулсан.			
				4.Сэтгэц наркологиын тасагт архины хамаараалтай 1 иргэнийг 2 удаа хэвтүүлсэн.			

					5.Тамхи, электрон тамхины хор нөлөөний талаар 2 постер хийн 2 усан сан, тоглоомын талбай, 11 хүнсний дэлгүүрийн мэдээллийн самбарт байршуулсан. 6."Явуулын үйлчилгээ" тусгай арга хэмжээний хүрээнд бүлэг бөөгнөрөл үүсгэдэг, архидан согтуурдаг 7 өрхөөр багийн Хэсгийн байцаагч, цагдаатай хамтран 19:00-22:00 цагийн хооронд 2 удаа гэр айлчлал эргүүл хийн хяналт тавин ажилласан. Нийт 41 иргэн хамруулав.				
2.	Арга хэмжээ 2.2. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, нийтийн биеийн тамираар хичээллэгчдийг нэмэгдүүлэх	2.2.1. Нийтийн биеийн тамираар хичээллэгчдийн эзлэх хувиар	12	15	15-64 насны 1000 иргэн байгаагаас бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд 99, "ХИЙН ДАСГАЛ"-ын аймаг, сумын аварга шалгаруулах тэмцээнд 9, Эрүүл чийрэг-Өвөрхангайчууд спортын арга хэмжээнд 5, Эрүүл чийрэг-Өвөрхангайчууд уриан дор зохион байгуулсан "Бүх нийтийн гүйлт-2024" марафон гүйлтэд 3 нийт 116 иргэн хамрагдаж 15-64 насны 11 хувь хамрагдсан байна. 1.15-64 насны иргэдээс бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд 04 дүгээр сард 35 иргэн, 05 дугаар сард 44, 10 сарын цэрэг татлагаар 19 иргэн хамруулж, 99 иргэн, үүнээс эрэгтэй 66, эмэгтэй 33 иргэн хамрагдсан. Сорилд А-12, В-15, С-18, D-27, F-27 үнэлгээтэй байсан.Тус сорилын мэдээллийг Биеийн тамир, спортын улсын хорооны Өвөрхангай БТСГ-ийн цахим программд шивж оруулсан. 2.МУ-ын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй "Эрүүл Монгол хүн" үндэсний хөдөлгөөний хүрээнд ахмад настны бие бялдрыг чийрэгжүүлэх, тэднийг хөдөлгөөний хомсдол болон халдвар бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, чөлөөт	2024.01.02 2024.11.25	70		

					цагийг зөв боловсон өнгөрүүлэх, дасгал хөдөлгөөнөөр хичээллэгсдийн тоог нэмэгдүүлэх зорилготой зохион байгуулагдсан "ХИЙН ДАСГАЛ"-ын сумын аварга шалгаруулах тэмцээнд 9 ахмад оролцож "ТЭРГҮҮН" байр мөн Өвөрхангай аймгийн аварга шалгаруулах тэмцээнд "ХОЁРДУГААР" байранд тус тус шалгарч амжилттай оролцсон. 3.Эрүүл чийрэг-Өвөрхангайчууд спортын арга хэмжээ спортын 4 төрөлд 5 иргэн оролцож теннис 3-р байр1, гар барилдаан 2-р байр1, дартс 3-р байр 1 шагналт байр эзэлсэн.			
3.	Арга хэмжээ 2.3. Соёлын биет тээгчдийн гаргаж, шавь хөгжүүлж, уламжлагчдын нэмэгдүүлнэ	бус өв судалгааг өвлөн тоог	2.3.1. Судалгаанд баяжилт хийсэн тоогоор	2	1	Соёлын биет бус өв тээгч 2 иргэний судалгаа гаргаж, шавь сургалтаар 1 иргэнийг бүртгэн авч баяжилт хийсэн.	2024.01.02 2024.11.25	100
			2.3.2. Соёлын биет бус өв тээгчийг сурталчилсан арга хэмжээний тоогоор	-	2	1.Өв соёлоо түгээн дэлгэрүүлэх танин мэдэхүйн арга хэмжээ Өвөрхангай аймгийн музейтэй хамтран түүх соёлын дурсгалт зүйл, өв уламжлалаа хамгаалах, урлагын бүтээлээр дамжуулан зорилтот бүлгийн 5 хүүхдийг үнэ төлбөргүй үзүүлж сурталчилан таниулсан. 2.Монгол Улсын Хөдөлмөрийн Баатар, Гавьяат тамирчин, Даяар дуурсагдах, Далай даян, Дархан аварга Дашдоржийн Цэрэнтогтохын нэрэмжит Үндэсний бөхийн 2024 оны хүүхдийн "Улсын аварга" шалгаруулах анхдугаар барилдаан зохион байгуулагдаж соёлын биет бус өв тээгчийг сурталчилсан арга хэмжээнд оролцож бүртгэл, зохион байгуулалтын үйл ажиллагаанд хамрагдан ажилласан.	2024.01.02 2024.11.25	100
	Арга хэмжээ 2.4. Өрхийн дунд угийн бичиг хөтөлтийг эрчимжүүлэх, сургалт арга хэмжээг	бичиг санд баяжилт хийх	2.4.1. Угийн бичиг санд баяжилт хийх			1."Нэг өрх- Нэг угийн бичиг" аяны хүрээнд иргэдийг угийн бичиг хөтлүүлэх, хойч үедээ өвлүүлэх, түгээн дэлгэрүүлэх зорилгоор угийн бичиг хөтлөх арга зүйн сургалтад 13		

4.	онговчтой зохион байгуулах	хөтөлдөг өрхийн тоог нэмэгдүүлсэн тоогоор	7	10	хэсгийн ахлагч хамрагдсан. 2. 2,7,12 дугаар баг хамтран "Угийн бичиг хөтлөлт" сургалт зохион байгуулж 21 иргэнийг хамруулсан. 3.Арвайхээр сумын 13 баг хамтран "Угийн бичиг хөтлөх арга зүй" сургалт зохион байгуулж 4 иргэн. Нийт 38 иргэнийг хамруулав. Угийн бичиг хөтлөх анхан шатны мэдлэгтэй, цаашдаа хөтлөх 3 иргэн нэмэгдсэн.	2024.01.02 2024.11.25	100
5.	Арга хэмжээ 2.5. Зорилтот жилийн ажлыг зохион байгуулах	2.4.2. Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоо	2	3	1.Аймгийн төв номын сангаас "Нэг өрх-Нэг угийн бичиг" сургалтыг нийгмийн ажилтануудтай хамтран зохион байгуулж багийн 13 хэсгийн ахлагч хамруулсан. 2.Эмт 2-р баг , Дэлгэрэх дэнжийн 7-р багтай хамтран "Угийн бичиг хөтлөлт" сургалт зохион байгуулж 21 иргэн хамрагдсан. 3.Арвайхээр сумын 13 баг хамтран "Угийн бичиг хөтлөх арга зүй" сургалт зохион байгуулж 2 өрхийн 4 иргэн хамрагдсан. Нийт 38 иргэнийг хамруулсан.	2024.01.02 2024.11.25	100
6.	Арга хэмжээ 2.6. Сум, багийн хэмжээнд туршлага болохуйц шинэ ажил санаачлан хэрэгжүүлэх	2.5.1. Зорилтот жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар 2.6.1. Шинээр санаачилсан ажлын тоогоор	100	100	"Цахим шилжилтийг эрчимжүүлэх" зорилтот жилийн хүрээнд төлөвлөгөө гарган ажиллаж төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувьтай байна. 1.Багийн 15 хэсгийн ахлагч нартай ярьж төлөвлөн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд ахуйн хүрээнд бөөгнөрөл үүсгэн архидан согтуурдаг хар цэгтэй гудамжыг камержуулах ажил зохион байгуулж төлөвлөсөн боловч төлөвлсөн санхүүжилт хуримтлагдаагүй учир хэрэгжээгүй болно. 2.Сургуулиас хол гэртэй хүүхдүүдэд зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор 50 ширхэг цацруулагчтай ханцуйвч туршилтаар хийх ажил	2024.01.02 2024.11.25	90

					төлөвлөсөн хойшилсноор	боловч төлөвлөсөн	санхүүжилт хугацаандаа	
Зорилт 3. "Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах"								
1.	Арга хэмжээ 3.1. Жилийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон бусад хөтөлбөр төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулах, дүгнүүлэх	3.1.1. Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	100	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2023оны 98 дугаар тушаалаар батлагдсан төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг аймаг, сумын засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж төлөвлөгөөг хагас, бүтэн жилээр гарган төсвийн шууд захирагчид хянуулж дүгнүүлсэн.			
2.	Арга хэмжээ 3.2. Хугацаатай албан бичиг, тайлан мэдээ, судалгааг бүрэн үнэн зөв гаргаж хугацаанд нь холбогдох газруудад хүргүүлэх	3.2.1. Өргөдлийн шийдвэрлэлтийн хувиар	100	100	1.Хүүхдийн мөнгөн тэтгэмжтэй холбоотой нэг өргөдөл ирсэнийг шийдвэрлүүлсэн. 2. Энэ оны эцсийн байдлаар амжиргаа дэмжих хурал 11 удаа хуралдаж байнгын асаргааны сунгалт 6, асран хамгаалагчаа солиулах 2, шинээр асаргаанд орсон 6, ӨТЭХийн тэтгэмж 1, малжуулах 1, тэжээгчээ алдсан тэтгэмж 2, бүтэн өнчин хүүхдийн асран хамгаалагч 1, "Онцгой байдал"-ын тэтгэмж 2, түлшний хөнгөлөлт 18 нийт 40 иргэний өргөдлийг шийдвэрлүүлэв.			
		3.2.2. Хугацаатай албан бичиг болон мэдээ хүргүүлсэн тоогоор	100	100	Хугацаатай албан бичиг 29 ирсэн. Хугацаатай албан бичгийн хариуг хугацаанд нь гарган холбогдох албан тушаалтанд хүргэн ажилласан.			
		3.2.3. Сарын ажлын мэдээний тоогоор	12	12	Зохион байгуулагчид сар болгон хийсэн ажлын мэдээгээ нэгтгэн өгдөг.			
3.	Арга хэмжээ 3.3. Статистик мэдээ тайлан, тооллого судалгаа, мэдээллийн санд баяжилт хийх	3.3.1. Нийгмийн зарим үзүүлэлт мэдээ	12	12	Үндэсний статистикийн программд шивэлт хийгдэх хугацаа болоогүй. Зорилтот бүлгийн иргэдийн нарийвчилсан судалгаанд баяжилт хийсэн.			

4.	Арга хэмжээ 3.4. Өө зүйн болон ашиг сонирхолын зөрчилгүй ажиллах	3.4.1. Иргэдээс ирсэн гомдол мэдээлэл ирүүлэггүй байх	12	12	Ашиг сонирхлын болон ёс зүйн зөрчил гаргаагүй ажилласан байна.	2024.01.02 2024.11.25	100
5.	Арга хэмжээ 3.5. Байгууллагаас зохион байгуулж байгаа олон нийтийн арга хэмжээнд идэвх санаачилгатай оролцох	3.5.1. Зохион байгуулсан ажилд оролцсон тоогоор	-	4	1.БООТөвөөс зохион байгуулсан өглөөний цай уулзалт болон олон нийтийн арга хэмжээнд оролцсон. 2.Байгууллагын эцэг, эхийн зөвлөлөөс зохион байгуулсан "Өөртөө цаг гаргаа" арга хэмжээнд оролцсон. 3.Байгууллагын ёс зүйн дэд хорооноос зохион байгуулсан "Ёс зүйгээрээ манлайлая" өдөрлөгт оролцсон. 4.Насан туршийн боловсролын төвтэй хамтран зохион байгуулсан Мэдээлэл харилцаа, холбоо технологийн сургалтад хамрагдсан.	2024.01.02 2024.11.25	100

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ) -ын биелэлт

Д /д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1.	Тухай бүр ажиллах	100	100	Багийн 24 өрхөд угаар мэдрэгч тарааж, ашиглах заавар, мэдээлэл өгч ажиллав.	2024.01.02 2024.11.25	100
2.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2.	Тухай бүр ажиллах	100	100	1."Явуулын үйлчилгээ" тусгай арга хэмжээний хүрээнд Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, бүлэг бөөгнөрөл үүсгэдэг, архидан согтуурдаг өрхөөр багийн Хэсгийн байцаагч, цагдаатай хамтран 19:00-22:00 цагийн хооронд 2 удаа эргүүл хийн хяналт тавин ажилласан. 2."Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь" арга хэмжээний хүрээнд 18:00- 21:00 цагийн хооронд хяналт шалгалтаар эргүүл хийн ажилласан.	2024.01.02 2024.11.25	100
3.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3.	Тухай бүр ажиллах	100	100	Сэтгэц наркологиын тасагт архины хамааралтай 1 иргэнийг 2 удаа хэвтүүлэн хордлого тайлах эмчилгээнд хамруулсан.	2024.01.02 2024.11.25	100

4.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4.	Тухай бүр ажиллах	100	100	Үндэсний бөхийн 2024 оны хүүхдийн "Улсын аварга" шалгаруулах анхдугаар барилдаан зохион байгуулагдаж бүртгэл, зохион байгуулалтын үйл ажиллагаанд хамрагдан ажилласан.	2024.01.02 2024.11.25	100
5.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 5.	Тухай бүр ажиллах	100	100	Арвайхээр хотын Захирагчын албанаас зохион байгуулсан бүх нийтийн цвэрлэгээ жилд 3 удаа хийгдэж иргэдээ хамруулан ажилласан.	2024.01.02 2024.11.25	100
6.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 6.	Тухай бүр ажиллах	100	100	8 сард орсон хүчтэй усархаг, аадар борооны улмаас гэр нь нурж уерт аетсан 1 өрхийг 20:00-23:00 цагийн хооронд Бурхи 9 дүгээр баг аавынх нь хашаанд нүүлгэн шилжүүлж ажилласан.	2024.01.02 2024.11.25	100

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д /д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	5		
1.	Арга хэмжээ 1. Боловсролын зэрэг ахиулах, эрдэм шинжилгээ судалгааны ажил хийх	2 Монгол бичгийн анхан, дунд шатны сургалтыг цахимаар судалж суралцсан байх	3 100	4 100	"Хүмүүн бичигтэн" аяны хүрээнд үндэсний бичгийн анхан, дунд шатны сургалтад хамрагдаж унших, гараар бичих, компьютерт шивэх чадварт суралцаж батламж авсан.	2024.01.02 2024.11.25	100	
2.	Арга хэмжээ 2. Мэргэшүүлэх сургалтад хамрагдах	Сэтгэл зүйн зөвлөгөө мэдээлэл өгөх чадвартай болсон байх	100	100	"Сэтгэцийн гэмтэлд суурилсан нийгэм- сэтгэлзүйн анхан шатны зөвлөгөө, үйлчилгээг бэлгийн хүчирхийллийн даван туулагч хүүхдэд үзүүлэх нь" 16 цагийн сургалтад хамрагдаж сертификат авсан.	2024.01.02 2024.11.25	100	

3.	Арга хэмжээ 3. Богино болон чиглүүлэх сургалтад хамрагдах	Нийгмийн ажилтануудын богино хугацааны чадавхжуулах сургалтад хамрагдсан байх	100	100	ХГБХХГазар, Галт шувуу хамтарсан Хүүхдийн тусламжийн 108 утасны хариу үйлчилгээний программ ашиглалт, кейс бүрдүүлэлтийн талаар 13 багийн хамтарсан багийн нарийн бичгүүдийг чадавхжуулах 3 цагийн сургалтад хамрагдсан.	2024.01.02 2024.11.25	100
4.	Арга хэмжээ 4. Төрийн албаны ерөнхий шалгалт өгөх	Төрийн албаны ерөнхий шалгалтад тэнцсэн байх	100	100	4 дүгээр улирлын төрийн албаны ерөнхий шалгалтад тэнцэж төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэгдсэн.	2024.11.20	100

ТАЙЛАН ГАРГАСАН:
НИЙГМИЙН АЖИЛТАН


О.МӨНХЦЭЦЭГ / /

2024.11.25